



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/41/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3-17
3. Аудитын тайлан.....	17-20
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	20-22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	21-22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ОНТС	Орон нутгийн төсвөөс санхүүжих



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

᠘᠔᠘᠘-᠐᠔-1᠔ № ᠑᠐
танай _____ ны № _____ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ж.БЭЛГҮҮТЭЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гурванбулаг сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ковидын урамшуулал болон тэтгэмжийн зардалд 13398648 төгрөгийг давхардуулан олгосон, 164550 төгрөгийн шатахуун зарцуулалт нь даргын цохолтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, 580090 төгрөгийн эм орлогодоогүй, эмийн тайлан зөрүүтэй тайлагнагдсан зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтууд, ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаал шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийт зөрчлийн 28079558 төгрөгийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

006020149

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,634,285.92	283,679,914.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,005,973.94
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,005,973.94
3121	Төгрөг	-	2,005,973.94
31211	Төрийн сангийн харилцах	-	1,358,163.94
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	647,810.00
33	АВЛАГА	-	209,010,081.65
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	209,010,081.65
35	БАРАА МАТЕРИАЛ	40,634,285.92	72,663,859.18
351	Түүхий эд материал	13,765,725.45	48,734,938.81
35110	Тусгай зориулалттай материал	7,996,912.95	11,444,340.83
35130	Эм боох материал	5,768,812.50	37,290,597.98
354	Хангамжийн материал	26,868,560.47	23,928,920.37
35410	Бичиг хэргийн материал	543,600.00	212,800.00
35420	Аж ахуйн материал	20,062,976.77	21,770,401.77
35460	Хүнсний материал	6,261,983.70	1,945,718.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	336,243,441.42	350,773,348.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	336,243,441.42	350,773,348.59
392	Биет хөрөнгө	321,363,441.42	335,893,348.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	486,968,641.86	486,968,641.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(285,910,966.37)	(294,215,344.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,144,434.00	126,144,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,641,150.16)	(53,058,688.99)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,288,060.41	141,644,509.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,936,267.19)	(76,958,544.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,207,820.69	38,207,820.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,757,131.82)	(32,839,480.00)
393	Биет бус хөрөнгө	14,880,000.00	14,880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,880,000.00	14,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>376,877,727.34</u>	<u>634,453,263.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>679,690.00</u>	<u>27,243,847.37</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	679,690.00	27,243,847.37
413	Өглөг	679,690.00	27,243,847.37
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,568,393.72
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	679,690.00	16,458,629.65
4136	Бусад өглөг	-	8,216,824.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	976,900.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	7,239,924.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>376,198,037.34</u>	<u>607,209,415.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	376,198,037.34	607,209,415.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,351,125.19	276,351,125.19
51101	Өмч: - төрийн	276,351,125.19	276,351,125.19
512	Хуримтлагдсан үр дүн	(101,681,496.67)	129,329,881.98
51210	Өмнөх үеийн үр дүн	(101,681,496.67)	(101,681,496.67)
51220	Тайлант үеийн үр дүн	-	231,011,378.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,528,408.82	201,528,408.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>376,877,727.34</u>	<u>634,453,263.36</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	709,701,423.72	1,355,509,126.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,332,103.72	316,895,582.27
120	Нийтлэг татварын бус орлого	29,332,103.72	316,895,582.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,332,103.72	316,895,582.27
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		57,621,449.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		259,274,132.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,332,103.72	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	680,369,320.00	1,038,613,544.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	612,353,700.00	440,648,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,442,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	404,911,000.00	440,648,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,881,400.00	524,277,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,881,400.00	524,277,542.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,467,000.00	53,380,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,467,000.00	53,380,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,667,220.00	20,306,902.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,667,220.00	20,306,902.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	562,075,309.32	1,124,497,747.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	562,075,309.32	1,124,497,747.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	559,517,321.22	1,088,897,747.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,615,999.90	442,896,388.43
210101	Үндсэн цалин	204,495,369.90	209,270,174.96
210102	Нэмэгдэл	94,805,230.00	94,271,105.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,465,992.84
210104	Урамшуулал	20,315,400.00	132,889,114.68

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,391,300.00	57,399,995.35
210201	Тэтгэврийн даатгал	27,606,700.00	39,631,345.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,196,200.00	4,155,379.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,556,900.00	3,970,638.00
210204	Ажилгүйдлийн даатгал	639,200.00	1,361,022.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,392,300.00	8,281,611.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,282,788.00	50,230,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,917,143.00	3,249,000.00
210302	Түлш, халаалт	36,365,645.00	46,981,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,092,865.00	35,121,403.00
210401	Бичиг хэрэг	3,979,820.00	4,955,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,012,240.00	20,247,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	952,015.00	1,393,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,742,750.00	5,583,030.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,098,240.00	2,942,043.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	307,800.00	-
2105	Нормативт зардал	74,556,217.92	430,117,106.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,948,004.72	407,686,601.03
210502	Хоол, хүнс	5,965,213.20	22,430,505.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,643,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,018,954.54	9,637,065.32
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,372,554.54	648,765.32
210604	Урсгал засвар	5,646,400.00	8,988,300.00
2107	Томилолт, зочны зардал	838,000.00	1,462,000.00
210702	Дотоод албан томилолт	838,000.00	1,462,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,575,467.00	10,655,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,968,567.00	8,736,385.00

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	606,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	188,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00
210807	Газрын төлбөр	-	82,777.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,145,728.86	51,377,407.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,199,503.00	2,550,865.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	444,400.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,501,825.86	48,826,542.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,557,988.10	35,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	280,000.00	35,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,277,988.10	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,277,988.10	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>147,626,114.40</u>	<u>231,011,378.65</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>147,626,114.40</u>	<u>231,011,378.65</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>680,369,320.00</u>	<u>830,730,965.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>680,369,320.00</u>	<u>830,730,965.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	612,353,700.00	440,648,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,442,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	404,911,000.00	440,648,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,881,400.00	316,394,963.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,881,400.00	316,394,963.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,467,000.00	53,380,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,467,000.00	53,380,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,667,220.00	20,306,902.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,667,220.00	20,306,902.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	469,926,620.00	822,989,991.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,926,620.00	822,989,991.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,368,631.90	787,389,991.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,615,999.90	439,197,492.06
210101	Үндсэн цалин	203,154,299.90	205,571,278.59
210102	Нэмэгдэл	96,146,300.00	94,271,105.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,465,992.84
210104	Урамшуулал	20,315,400.00	132,889,114.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,391,300.00	58,527,498.00
210201	Тэтгэврийн даатгал	27,606,700.00	40,758,848.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,196,200.00	4,413,779.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,556,900.00	3,970,638.00
210204	Ажилгүйдлийн даатгал	639,200.00	1,102,622.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,392,300.00	8,281,611.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,895,143.00	50,230,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,545,299.00	3,249,000.00
210302	Түлш, халаалт	17,349,844.00	46,981,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,052,705.00	25,133,113.00
210401	Бичиг хэрэг	1,460,000.00	1,668,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,039,240.00	17,564,633.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	952,015.00	1,303,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,101,750.00	3,122,500.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,499,700.00	1,473,580.00
2105	Нормативт зардал	50,737,314.00	189,191,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,033,084.00	180,542,060.00
210502	Хоол, хүнс	7,488,530.00	8,649,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,215,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,553,600.00	11,658,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,405,000.00
210604	Урсгал засвар	3,053,600.00	10,253,000.00
2107	Томилолт, зочны зардал	838,000.00	1,462,000.00
210702	Дотоод албан томилолт	838,000.00	1,462,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,575,467.00	5,633,158.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,968,567.00	3,713,761.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	606,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	188,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00
210807	Газрын төлбөр	-	82,777.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,709,103.00	6,356,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,709,103.00	6,356,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,557,988.10	35,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	280,000.00	35,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,277,988.10	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,277,988.10	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>210,442,700.00</u>	<u>7,740,973.94</u>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	5,735,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	5,735,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	5,735,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,000,000.00	5,735,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,000,000.00)	(5,735,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	207,442,700.00	2,005,973.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,005,973.94

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(101,681,496.67)		376,198,037.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(101,681,496.67)	-	376,198,037.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	231,011,378.65		231,011,378.65
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82		-	477,879,534.01
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	(101,681,496.67)	-	376,198,037.34

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	231,011,378.98	-	708,890,912.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	231,011,378.65	-	231,011,378.65
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	129,329,882.31	-	607,209,416.32

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	845106963.00	512977838.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845106963.00	507242838.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	808506963.00	507242838.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	441377442.00	333349450.06
210101	Үндсэн цалин	212417100.00	205571278.59
210102	Нэмэгдэл	95391553.00	89949852.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6552000.00	6465992.84
210104	Урамшуулал	127016789.00	31362325.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58532498.00	45296500.00
210201	Тэтгэврийн даатгал	40872382.00	31761766.00
210202	Тэтгэмжийн даатгал	4413779.00	3355300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3975638.00	2684200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1102622.00	671100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	8168077.00	6824134.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50731300.00	50230600.00
210301	Гэрэл, цахилгаан	3249000.00	3249000.00
210302	Түлш, халаалт	46982300.00	46981600.00
210303	Цэвэр, бохир ус	500000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25433933.00	23246880.00
210401	Бичиг хэрэг	1760000.00	1668500.00
210402	Тээвэр, шатахуун	17564633.00	15678400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,303,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,122,500.00	3,122,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,473,580.00
2105	Нормативт зардал	196,580,360.00	39,827,110.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,157,960.00	32,202,480.00
210502	Хоол, хүнс	9,852,400.00	7,624,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,570,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,862,000.00	2,920,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	1,120,000.00
210604	Урсгал засвар	10,362,000.00	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,527,330.00	462,000.00
210702	Дотоод албан томилолт	1,527,330.00	462,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,687,100.00	5,633,158.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,624,100.00	3,713,761.00
210803	Даатгалын үйлчилгээ	232,000.00	232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,500.00	188,620.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
210807	Газрын төлбөр	90,500.00	82,777.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,775,000.00	6,277,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,775,000.00	6,277,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,600,000.00	-

2132	Бусад урсгал шилжүүлэг	36,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,600,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,735,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,735,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	5,735,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	514,336,002.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	440,648,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	440,648,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	53,380,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	53,380,600.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	20,306,902.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	20,306,902.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,358,163.94
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	315,747,153.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,747,153.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,147,153.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,848,042.00
210102	Нэмэгдэл	4,321,253.00
210104	Урамшуулал	101,526,789.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,230,998.00

210201	Тэтгэврийн даатгал	8,997,082.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,058,479.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,286,438.00
210204	Ажилгүйдлийн даатгал	431,522.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,457,477.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,886,233.00
210402	Тээвэр, шатахуун	1,886,233.00
2105	Нормативт зардал	149,364,480.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,339,580.00
210502	Хоол, хүнс	1,024,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,738,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	285,000.00
210604	Урсгал засвар	8,453,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	316,394,963.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	316,394,963.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	316,394,963.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	647,810.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын ЭМТ нь “Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанар, аюулгүй байдлыг хангаж үйлчлэх” гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлагын 562.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 823.0 сая төгрөгөөс 2 хувь буюу 16.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож ажиллалаа.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гурванбулаг сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 440.6, орон нутгийн төсвөөс 61.9, ЭМДС-гаас 32.7 сая төгрөг буюу нийт 535.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 440.6, орон нутгийн төсвөөс 53.4, ЭМДСангаас 20.3, нэмэлт дансаар 316.4 сая төгрөг буюу нийт 830.7 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 828.7 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн гүйлгээний тайлангаар 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гурванбулаг сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 316.4 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 315.8 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гурванбулаг сумын ЭМТ нь 2021 онд ковид, цар тахалтай холбогдуулаад 256.6, дарлаажуулалтын 1, 2-р тун 20.4 сая төгрөг буюу нийт 277.0 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр цалин урамшуулалд 104.5, НДШ-д 13.2, хоол хүнсний зардалд 1.5, эм эмнэлгийн хэрэгсэлд 148.4, урсгал зардалд 8.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тус сумын ЭМТ нь 2021 онд ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн мөнгөн тэтгэмж урамшуулалд 35.6, ковидын урамшуулал, нэмэгдэл цалингийн зардалд 104.5 сая төгрөгийг тус тус олгожээ.

Хандив тусламжаар ЭМЯ болон ЭМГ-аас 57.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 259.3 сая төгрөгийн бараа материалын орлого авч үндсэн хөрөнгө, бараа материалын тодруулга тайланд тайлагнажээ.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй 1.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийх албан тоот хүсэлтийн дагуу санхүүгийн тайланд залруулга хийж баталгаажууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор ковидын урамшуулалыг давхардуулан 13.4 сая төгрөгийг олгосон, 0.6 сая төгрөгийн эмийн орлого, дутуу, анхан шатны баримтын бүрдэлд дутуу даргын цохолтгүй шатахуун зарцуулсан, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх мэдээллийг бүрэн мэдээлж ажилласан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээлийг бүрэн мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 22 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан ч өмнөх алдаа давтагдаж байгаа нь зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй биелүүлж өмнөх алдаа зөрчил давтагдсан тул хариуцлага тооцох албан шаардлага хүрүүлж ажиллалаа.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 оноос эхлэн гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаатай холбогдуулан өөрийн орлого болон гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 6.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 1.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Өглөгийн тайланд 1.4 сая төгрөгийн өглөгийг илүү, дутуу тайлагнасан зөрчлийг НББ-ийн тухай 15 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийж баталгаажуулан ажиллалаа.

4.2 Төлбөрийн акт

1. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны эмийн орлого, зарлага зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 580090 төгрөгийн эмийн орлого дутуу, зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны ковид цар тахалтай холбогдуулан олгосон тэтгэмж, урамшуулалыг түүвэрлэн шалгахад 13398648 төгрөгийг хүчингүй болсон хуулийн заалтыг үндэслэн тэтгэмж давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, даргын цохолтгүй 164550 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өглөгийн 6.2 сая төгрөгийг холбогдох байгуулагаар баталгаажуулж, тооцоо нийлж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20 дугаар 2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гурванбулаг сумын ЭМТ	6	21.7	2	1.4	3	14.1	0	0	1	6.2

